

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг
зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн арван
нэгдүгээр хуралдааны тэмдэглэл /2012-12-23/**

Үндэсний зөвлөлийн аравдугаар хуралдаан 2013 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 17 цаг 00 минутад Төрийн ордны "А" танхимд эхлэв.

Хуралдаанд Үндэсний зөвлөлийн дарга, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч Д.Дамба, Эрдэнэт үйлдвэрийн Маркетингийн товчооны дарга Д.Галбаатар, Монполимет ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Энхтуяа, Монголпросцветмет ХХК-ийн хангамжийн хэлтсийн дарга М.Болдбаатар, Хүний эрх, хөгжил төвийн тэргүүн Г.Уранцоож, Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, Хөвсгөл далайн эзээз ТББ-ын тэргүүн Б.Баярмаа, Ариун суварга хөдөлгөөний тэргүүн Г.Чагнаадорж, Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүн Ж.Гомбожав, Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүн Б.Батболд, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ерөнхий сайдын ахлах зөвлөх Л.Гансүх, Үндэсний зөвлөлийн орлогч дарга, Уул уурхайн сайд Д.Ганхуягийг орлож Уул уурхайн яамны Стратеги бодлого төлөвлөлтийн газрын дарга Ч.Отгочулуу, мөн газрын хэлтсийн дарга Д.Нэргүй, Сангийн сайд Ч.Улааныг орлож Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн газрын мэргэжилтэн Г.Зулай, Авилгатай тэмцэх газрын дарга Н.Ганболдыг орлож Авилгатай тэмцэх газрын албаны дарга, ахлах комисsar Л.Сүх-Очир, Оюу толгой ХХК-ийн ерөнхийлөгч Камерон Макрейг орлож Оюу толгой ХХК-ны олон талт хамтын ажиллагааны ахлах мэргэжилтэн Х.Лхамаа, Энержи ресурс ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Батцэнгэлийг орлож компанийн нийгмийн хариуцлага, олон нийттэй харилцах газрын мэргэжилтэн н.Отгонтуяа, Өрмөн уул ХХК-ны ерөнхий захирал Д.Оюунбилэгийг орлож мэргэжилтэн Б.Буянт, Хариуцлагатай уул уурхайн ТББ-ын тэргүүн Л.Долгормааг орлож ТАН эвслийн ажилтан Д.Уранчимэг, Нээлттэй нийгэм форумын менежер Н.Дорждарийг орлож Миний монголын газар шороо хөдөлгөөний гүйцэтгэх захирал Б.Отгонсайхан нар оролцов.

Хуралдаанд Үндэсний зөвлөлийн 30 гишүүдээс 20 гишүүд оролцож ирц 66 хувьтай байв.

Мөн хуралдаанд урилгаар Ашигт малтмалын газрын дарга Г.Алтансүх, уул уурхайн хэлтсийн дарга С.Баттулга, мэргэжилтэн Д.Мөнхсайхан, Татварын ерөнхий газрын дэд дарга А.Энхболд, ахлах байцаагч Д.Энхтуяа, Далайван аудит корпораци ХХК-ийн ерөнхий захирал Б.Жигдэн, ахлах аудитор Б.Гантулга, аудитор Ц.Ганболд, Т.Отгонбат, Б.Мөнгөнтулга, Д.Болорбаяр, Адам Смит интернэйшнл байгууллагын менежер П.Оюунбилэг, ОУИТБС-ын ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, санхүүгийн мэргэжилтэн А.Отгонтунгалаг нар оролцов.

Хуралдааныг Үндэсний зөвлөлийн дарга, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг нээж үг хэлэв. (хэлсэн үгийг хавсаргав)

Энэ удаагийн хуралдааныг Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ерөнхий сайдын ахлах зөвлөх Л.Гансүх удирдан чиглүүлэн бөгөөд хэлэлцэх 4 асуудлыг танилцуулж, хуралдааны дотоод журмыг гишүүдээс санал авч баталснаар хуралдааныг эхлүүлэв.

I. ХЭЛЭЛЦСЭН нь: Британийн Muur Stefens, Монголын Далайван аудит компаниудын консерцумын боловсруулсан Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2012 оны нэгтгэл тайлан

Б. Жигдэн: Монгол Улсын ОУИТБС-ын долдугаар буюу 2012 оны нэгтгэлийн тайлангийн товч танилцуулав. /Танилцуулгыг хавсаргав/

Л.Гансүх: Бид тайланг ажлын хэсгээр хэлэлцээд хангалттай дүгнэсэн. Тайлантай холбоотой асуух хүнийг бүртгэв.

Ж.Гомбожав: Байгаль орчныг хамгаалах зардлыг тусгай дансанд байршуулах ёстай. Тайлангаар хэдэн байгууллагын дансанд хэдэн төгрөг байршуулаад байна вэ. Тусгай дансыг яам агентлагууд нээчихээд ашиглаад байна уу гэсэн хардлага байгаа тул задаргааг дэлгэрэнгүй мэдэх шаардлагатай байна. Хоёрдугаарт, яам агентлагийн авсан хандив тусlamжийн дэлгэрэнгүйг сонирхож байна. Гуравдугаарт, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийсэн мэдээллээ 129 компани ирүүлээгүй байна гэжээ. Аудит хийгдсэн 200 компаниас 129 нь гэж ойлгож байна. Мэдээ ирүүлээгүй компанийг нөхөн сэргээлтээ хийгээгүй байна гэж үзэж болох уу. Эдгээрийн дотор ураны 4 компани орсон байна.

Б.Жигдэн: Хандив тусlamжийн тухайд гэвэл 5 тэрбум төгрөг нь Бороо гоулд ХХК болон Эрүүл мэндийн яамны хооронд үүссэн тооцоо юм. Эрүүл мэндийн яаманд эмнэлэг барьж өгсөн гэж Бороо гоулд бүртгээд, харин Эрүүл мэндийн яам орлоготоо тусгаагүй байна. Төр талдаа ямар нэгэн байдлаар мэдээндээ оруулаагүй, харин Бороо гоулд талаас 5 тэрбум төгрөгийн ажил хийжээ. Нөхөн сэргээлтийн тухайд бол 129 компани мэдээгээ ирүүлээгүй гэдэг нь үнэн. Бидний ажлын даалгаварт энэ ажил орсон учир бид хийсэн. Харин гадаад зөвлөх маань энэ ажил нэгтгэлд оруулах шаардлагагүй гэж үзэж байсан. Өөр чиглэлийн байгууллага хийх ёстай ч, бид даалгаврын дагуу 80 орчим байгууллагын дүнг нэгтгэсэн. Манай ажлын даалгаварт сумаар нэгтгэнэ гэсэн зүйл байхгүй. 2307 тусгай тусгай зөвшөөрлийн эздийг тайлангийн 6 дугаар хавсралтаас харна уу. Харин аймгуудаар гарсан болно.

Л.Гансүх: Алтансүх дарга тайлбар өгнө үү. 2323 компани хайгуулын лиценз авсан хэдий ч ашиглалт явуулаагүй байж болох талтай. Тийм учир тусгай дансанд нь мөнгө хийгээгүй байж болно.

Г.Алтансүх: Хайгуулын лиценз бүхий компаниуд суман дээр нөхөн сэргээлтийн зардлынхаа 50 хувийг тусгай дансанд хийдэг.

Л.Гансүх: Зөвхөн хайгуул хийсэн тохиолдолд хийсэн байх ёстой юу. Эсхүл тусгай зөвшөөрөл авсан л бол нөхөн сэргээлтийн зардлыг байршуулдаг юм уу? Гомбожав гуай, 2323 компани бүгдээрээ нөхөн сэргээлтийн зардлыг хийсэн байх ёстой гэж үзэж байна. Та хэд мэргэжлийн байгууллагын хувьд хэлэх хэрэгтэй байна. Одоохондоо хэлэх тоо байхгүй бол дараа нь Гомбожав гуайд тоог нь гаргаж өгөөрэй. Ил тод байдлын санаачилга маань олборлолт эсхүл хайгуул хийчихээд түүнээс орсон орлогоо юунд зарцуулж байна гэдгийг ил тод байлгахад чиглэж байна. Бид 2014 онд гурван чухал ажил хийнэ. Нэгдүгээрт, цахим тайлагналыг ашиглах, хоёрдугаарт хууль батлуулах, гуравдугаарт хууль батлуулснаар тайлангаа гаргаагүй бол тусгай зөвшөөрөлтэй нь хариуцлага тооцох боломжтой болно. Бид гурван талаасаа асуудлаа зөвлөлдөөд, ойлголцож чадвал бэрхшээл багатай байх болно.

Б.Отгонсайхан: Нэгтгэл тайлангийн танаилцуулгын 12 дугаар хуудас дээр ТЕГ-ын орон нутгийн төлөгдсөн төлбөрүүд 15 тэрбум төгрөг гэснийг юу гэж ойлгох вэ?

Б.Гантулга: Нийт төлбөрийг улсын төсөвт, орон нутгийн төсөвт ордог гэж ангилдаг. Дурдсан төлбөр нь орон нутгийн төсөвт төлсөн гэсэн ангилалд орсон байсан. Үүнд татварын хяналт шалгалтын дүнгээр гарсан нөхөн төлбөр, алдангийн төлбөрүүд юм. Тодруулбал, компаниуд орон нутгийн төсөвт төлдөг гэсэн ангилалд тайлагнасан байсан төлбөрийн дүн юм.

Л.Гансүх: Өмнөговь орон нутгийн төсөвт өгсөн орлогоо гээд Татварын ерөнхий газарт хамаарна гээд давхардаж ойлгогдоод байна.

Б.Гантулга: Компаниуд орон нутгийн төсөвт төлсөн гэж буруу тайлагнасан байсан, эх сурвалжийг нягтлахад Татварын ерөнхий газарт төлсөн татвар байсан юм.

Л.Гансүх: Тайланд засвар оруулах, эсхүл хаалтанд бичвэл болно гэж үзэж байна.

А.Чагнаадорж: Гомбожав гуайн асуулт дээр нэмэж хэлэхэд улс тусгай зөвшөөрөл бүрээр татвар авдаг. Тусгай зөвшөөрлийн төлбөрөө хугацаандаа дотор төлөхгүй бол зөвшөөрлийг цуцална гэсэн зарыг сонинд нийтэлдэг..

Л.Гансүх: Байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг хэдэн компани төлсөн гэж асуусан. Таны асуулт өөр аргачлалаар тайлагнагдах ёстой.

Б.Батболд: Уул уурхайн компаниуд Засаг даргын тамгын газартай гэрээ хийвэл төлбөр төлөх үү?

Л.Гансүх: Үйл ажиллагаагаа эхлэх үед гэрээ хийдэг. Томоохон компаниудыг дүйцүүлэн нөхөн сэргээлт хийдэг. 30 жилийн дараа нөхөн сэргээлт хийнэ гэдэг баталгаа өгөхийн тулд тодорхой газарт дүйцүүлэн хамгаалалт хийнэ.

Д.Дамба: Тусгай зөвшөөрөлтэй компани бүр байгаль орчны нөхөн сэргээлтийн 50 хувийг заавал төлж байгаа, төлөх ёстой. Жил бурийн хайгуулын ажлын төлөвлөгөө хийхгүй бол зөвшөөрөл хураагддаг хуультай. Урьдчилгааг Байгаль орчин ногоон хөгжлийн яаманд байршуулдаг. Харин Байгаль орчин ногоон хөгжлийн яамнаас хүн байвал тайлбарлах хэрэгтэй байна. Энэ тоо 2012 оны тайлан учир Ашигт малтмалын газарт ирсэн баймаар юм. Харин зөрүү гарсан бол Байгаль орчин, ногоон хөгжлийн яаманд орсон байх.

Л.Гансүх: Гомбожав гуай бол орон нутгийн төсөвт (суманд) хичнээн төгрөг орсон гэж асууж байна.

Ж.Гомбожав: Хурлын бэлтгэлээ муу хийсэн байна. Хариуцсан сайд нар алга. Бид бүгд Үндэсний зөвлөлийн гишүүд шүүдээ.

Л.Гансүх: Уул уурхайн яамнаас Отгочулуу, Нэргүй нар иржээ. Бид энэ тайлан болон бусад ажлуудын талаар дотроо сайн хэлэлцээд хэвлэл мэдээллээр сурталчилах ёстой. Харин хуралдаа ирээгүй сайд нарт арга тооцуулахыг Ерөнхий сайдад уламжилья.

Санал хэлэх цаг.

П.Эрдэнэжаргал: Урьд оны тайланг дараа онд нь хэлэлцэж байгаа нь 3 талын оролцоо бэхжиж байгаагийн шинж юм. Харин тайланг нэгтгэсэн зөвлөхүүдийн зөвлөмжтэй санал нийлмээргүй байна. Манай улс бусад орнуудад үлгэр дуурайлал болж байгаа онцлогтой улс. Зөвхөн дундаж жишгийг хараад бидэнд дүгнэлт өгөөд байгааг хүлээн зөвшөөрөхгүй. Нэгтгэлийн ажлын өмнө хамрах хүрээг тогтоо судалгаа хийгээгүй гэдэг нь буруу дүгнэлт байна. Бид төлбөрийн босго тогтоогоод түүнээс дээш гарсан компаниудыг нэгтгэлд хамруулахаар болсон. 7 дугаар тайлан гарч, бид тодорхой туршлагатай болсон. Нөгөө талаас, орон нутагт өгсөн хандивыг оруулж ирсэн. Байгаль орчны нөхөн сэргээх зардлыг тайландаа оруулах нь зөв. Монгол улсад хэрэгтэй зүйл хийж байгаа тул өөрийн онцлогт тохирсон тайланг гаргах ёстой. Мөн компаниуд санхүүгийн тайлангаа аудит хийлгээд түүнд үндэслэн тайлангаа гаргах тухай л ярьж байна. Харин ОУИТБС-ын тайландаа аудит хийлгэх асуудал биш юм: Учир нь, бид нягтлан бodoх бүртгэлийг сайжруулах зорилт байгаа.

Б.Жигдэн: Гурван маягтын доод тал дээр дэмжих баримт бичгүүдийн хамт аудитаар баталгаажуулсан тэмдэг даруулах хэрэгтэй. Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн зорилго, стандарт, аргачлал нь байдаг. Харин 6 маягт дээр байгаа тоо нь барьцгүй байна. Олон улсын хэмжээнд гаргаж байгаа тул баталгаажуулах ёстой. Босго

тогтоох тал дээр Монголын онцлог гэж байхгүй, 40 сая төгрөг гэсэн нь дутуу харин олон шалгуур үзүүлэлтүүдээр гаргаж, судалж хийх нь зүйтэй. Ер нь ил тод байдлын санаачилга бол Авилгатай тэмцэх газар, татварын байгууллагын үүргийг гүйцэтгэдэг байгууллага биш. Авсан өгсөн зүйлээ олон түмэнд ил тод байлгах асуудал болохоос, хандив нь хулгай юу, завшсан уу гэдэг нь өөр асуудал юм. Тиймд хуулиар цэгцлэх хэрэгтэй юм.

Л.Гансүх: Гаргасан тайланг дахин аудитлах нь шаардлагагүй. Харин нягтлан, баталгаажуулах ёстой. Хэрэв нягтлан бодогч нь буруутай бол хуулийн дагуу хариуцлага тооцдог байх хэрэгтэй.

Н.Баярсайхан: Улсын төсөвт орж байгаа уул уурхайн орлогын дийлэнх хувийг эдгээр компаниуд бүрдүүлж байна. Харин үлдсэн орлогыг бусад компаниуд бүрдүүлж байна харьцуулан гаргах хэрэгтэй Мөн аймгуудаар нь, уул уурхайн орлогоор бие даасан аймгууд зэргээр сонирхолтой мэдээллийг тайландаа оруулах хэрэгтэй байна. Тайланг иргэд, иргэний нийгэм, сэтгүүлчид, судлаачид ашиглаж болохуйц ойлгомжтой, харьцуулах боломжтой мэдээллийг оруулах хэрэгтэй байна. Орон нутгийн шилжүүлэг гэдгийг сайн тодруулна уу. Тайланг хийх явцад тулгарсан асуудлууд гэдэг дүгнэлт дээр зарим оролцогч талуудын санаачилгын зарчмуудын талаарх ойлголт жигд бус түүнийг хэрэгжүүлэх хүсэл эрмэлзлэл бага гэсэн байна. Хэн буруу ойлголт, хэрэгжүүлэх хүсэл эрмэлзлэл багатай байгааг тодорхой гаргаж хэрэгтэй байна.

Ж.Гомбожав: Тусгай зөвшөөрөл эзэмшинэ гэдэг нь хариуцлага юм. Төлбөрөө төлж байна гэдэг нь хариуцлагатай байна гэсэн үг. Анх 1997 онд хуулийн үндэслэл дээр заасан байгаа. Байгаль орчныг нөхөн сэргээх ажлын 50 хувийг заавал тусгай дансанд хийх ёстой. Олборлолт хийлгүй, худалдахын тулд тусгай зөвшөөрөл хадгалж байгаа бүгд мэднэ. Хэрвээ энэ ажлыг төрийн байгууллага хийж чадахгүй байгаа бол төрийн нэрийн өмнөөс үүрэг гүйцэтгэх эрхийг нь төрийн бус байгууллагуудад өгөх хэрэгтэй байна. Бид 2014 онд уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг 138 суманд хяналт тавиад энэ ажлыг хяналт тавиад ажиллах бүрэн боломжтой байна. Иймд 2014 оны төлөвлөгөөндөө тусгасан ажлуудаас манай зөвлөл болон бусад иргэний байгууллагуудадаар гүйцэтгүүлэхээр тусгах хэрэгтэй байна гэсэн саналыг хэлмээр байна.

Д.Дамба: Ил тод байдлын санаачилга хэрэгжиж эхэлснээс хойш ахиц гарч байна, улам боловсронгуй болгох ёстой. Хамрагдаж байгаа компаниудын хүрээг өргөжүүлж, идэвхтэй оролцож байгааг нь сайшаан дэмждэг, тайлан гаргахгүй байгаад нь арга хэмжээ авдаг амьд ажиллагаа шаардлагатай байна. Тухайлбал, Доншень компани тайлангаа ирүүлээгүй байна. Үүнд ямар арга хэмжээ авах хэрэгтэй вэ? Хир шударга вэ. Хамрагдах гэрээг тодорхой болгох хэрэгтэй байна. Байгаль орчныг нөхөн сэргээх барьцаа төлбөр гэж ойлгомжгүй зүйл байдаг. Өнөөдөр нөхөн сэргээлтээ хийгээд орон нутагтадаар актаар хүлээлгээд өгчихсөн байхад тэр мөнгийг нь буцааж өгөх ёстой. Гэтэл

мөнгө ч үгүй, данс ч үгүй байх юм. Төрийн байгууллага үйлчилгээ үзүүлэхдээ маш хүнд сурталтай байдаг, авах болохоор бушуу өг гээд л авчихаад, өгөх болохоор өгдөггүй.

Манай Үндэсний зөвлөл бол ил тод байдлыг олон түмэнд хүргэх зорилготой. Гэтэл өнөөдрийн байдлаар энэ зорилго төдийлөн хангагдахгүй байна. Сурталчилгааны асуудал муу хийгдэж байна, материал нь зөвхөн энд сууж байгаа хэдэн хүний дунд тараагдаад, жаахан юм сонирхдог хүмүүс бол санаачилгын вэб сайт руу ороод харж болно. Гэтэл үүнийг хөдөө орон нутгийн иргэд яагаад ч ойлгохгүй, мэдээллийг авч чадахгүй байна. Иймээс сурталчилгааны ажлаа маш сайн хиймээр байна. тэгэхээр өнөөдөр хэлэлцээд нэг шийдвэрт хүрсэний дараа сонин хэвлэл, радио зурагтаар сайн мэдээллээр байна. Түүнчлэн сурвалжлагчдыг зарим хүмүүстэй уулзуулаад мэдээлэл, яриа авах зэрэг ажлыг зохион байгуулмаар байна. энэ хүмүүсийн яриад байгаа санал санаачилгыг олон нийтэд хүргэх, орон нутагт төвлөрсөн орлогыг нутгийн ард түмэнд мэдээлдэг байх нь зүйтэй юм.

Ч.Отгочулуу: Эрдэс баялагийн салбарт төрөөс барих бодлого ирэх 7 хоногт батлагдах байх гэсэн найдлагатай байна. Ил тод байдлын тухай, хууль болно гэсэн бүтэн заалт оруулсан. Хуулийн ажлын хэсэг яаманд ажиллаж байна. Бид эхлээд бодлогоо батлуулчихъя гэсэн зорилготой явж байна. 2013 онд яамны зүгээс Норвеги болон Сиднэйд зохиогдсон хоёр арга хэмжээнд оролцсон байгаа. Ганхуяг сайд өөрөө оролцсон. Саяхан би “Их найм” уулзалт арга хэмжээнд оролцсон. Хөгжиж байгаа ядуу буурай орнуудад чөлөөт зах зээлийн эдийн засгийн тухай ярьдаг ч барууны орнуудыг төлөөлж тэнд үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын ил тод байдал хангалтгүй байна гэдэг шүүмжлэл байна. Манайд Оюутолгой компанийтай маргаан гардаг шиг ийм маргаан бүх орон том гүрнүүдэд бас байна. Шалтгааныг олох, загвар гэрээ боловсруулах, ил тод, хариуцлагатай байдлыг хөгжүүлье, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн бодит нөлөөг үзүүлдэг болох зэрэг асуудлыг хэлэлцэн байна. Манай улсыг ихэд сонирхож, нэгдэж ажиллах, загвар орон болох талаар санал тавьж байна. Дөрвөн ажлын хэсгийг байгуулж 2030 он хүртэл дэлхийн нөөц баялаг, аж үйлдвэрийн салбар ямар байх, ядуурлыг хэрхэн буулгах, орлогын менежментийг хэрхэн сайжруулах, ил тод байдлыг сайжруулах, авилгатай хэрхэн тэмцэх гэсэн асуудлаар ажиллах болсон. Манай яамнаас хийгдэж байгаа нэг ажил бол уул уурхайн засаглалын индекс гаргадаг. Манай орон энэ үзүүлэлтээр дээр ухарсан байгаа. Үүнийг яаж сайжруулах талаар төлөвлөгөө стратеги боловсруулж байгаа. Энэ асуудал дээр Оюусити гэдэг байгууллагатай хамтран ажиллахаар тохирсон байгаа. Мөн 2014 оны 1 дүгээр сарын 15-нд “Эрдэс баялаг 2025” гэсэн олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулна. Гол нь уул уурхайн салбарын талаар ард иргэддээ зөв мэдээлэл өгөх зорилгоор энэ ажлын зохион байгуулна. Үүнээс гадна ил тод байдлын талаар салбар хуралдаан хийх бодолтой байгаа. Манай яамны хувьд санаачилгыг хэрэгжүүлэх ажилд идэвхтэй ажиллаж байгаа, ирэх онд ч сайн ажиллана.

Г.Уранцоож: Үндэсний зөвлөлийн ажилд ахиц дэвшил гарч байна. Би нөхөн сэргээлтийн зардлын 50 хувийг байршуулах асуудлыг анхаарч хардаг юм. Өмнөх тайлангаар 25 сая төгрөг байршуулсан гэсэн бол 2012 оны тайлангаар 2,5 тэрбум төгрөг байршуулжээ. Жил жилийн тайлангаас хараад бодлогын зөвлөмж боловсруулах бололцоотой байдаг. Гэтэл үүнийг хийхгүй байна. Одоогийн гарч байгаа зөвлөмжүүд ч шаардлага хангахгүй байна цаашид илүү сайн болгох хэрэгтэй байна. Тэгэхээр тайлан болгоны зөвлөмжийг харж байгаад манай өнөөгийн байгаа эрх зүйн орчин яагаад биелэхгүй байна, эрхзүйн орчин яагаад тохиромжгүй байна гэдэг дээр холбогдуулаад цаашид эрдэс баялагийн бодлогыг боловсруулахад илүү оновчтой, үр ашигтай болгоход зориулсан бодлогын зөвлөмжийг гаргах бүрэн боломжтой байна. Бид цаашдаа үүнийг хийж баймаар байна. Бид ТАН эвслээс өгсөн үүргийн дагуу зургаан удаагийн тайлангуудад өгсөн зөвлөмжийн дагуу Үндэсний зөвлөл юу хийсэн байна, юуг хийгээгүй гэдэг талаар мониторинг хийж байгаа. Энэ мониторингийн дүнг дараагийн хуралд та бүхэнд танилцуулах боломж гарах байх гэж найдаж байна.

2012 оны тайлангийн зөвлөмжтэй холбогдуулан тэдгээрийг хэрэгжүүлэх талаар эсхүл асуудалтай хэсгийг нь дахин боловсруулж нэгдсэн байр суурьтай болох тал дээр нэмэлт үйл ажиллагаа шаардлагатай байна. Нэгтгэл тайланг хараад байхад олон хуулиуд биелэхгүй байгааг харагддаг. Бид өмнө нь тайлангийн зөрүү дээр их анхаардаг байсан бол одоо зөрүү маань харьцангуй бага болсон тул энэ том нүсэр ажлыг хийгээд гарсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх талаар цаашилбал санаачилгыг илүү үр ашигтай хэрэгжүүлдэг болох вэ гэдэг тал дээр илүү их ажилмаар байна. Мөн нэгтгэл тайланг хийх цаг хугацааг өөрчлөх тал дээр анхаарч үзэх хэрэгтэй гэж үзэж байна. Иймээс 2013 оны нэгтгэл тайлангийн мэдээллийг цуглуулах ажлыг 2014 оны эхний хагаст багтааж хийх, эсхүл ийм ажлыг хийнэ гэж төлөвлөх нь хэрэгтэй байна.

Л.Гансүх: Бид өнгөрсөн хугацааны туршлагаас хараад хуулийнхаа асуудлыг шийдэж байж хариуцлага тооцох бүрэн боломжтой болно. Уул уурхайн яам биеэ даасан хуультай болох талаар ажиллаж байна. Ил тод байдлын санаачилгын 1 чиглэл нь орлогууд хэрхэн төлөгдөв, авилгатай эсэхийг анхаарах ёстой. Нөгөө талаас, хүнд сурталгүй, дарамтгүй байх ёстой. Тайланг цаг хугацаа хэмнэсэн цахим хэлбэрт шилжүүлэх, баталгааг байгууллагын нягтлан бодогч шууд хариуцдаг байх хэрэгтэй.

Нэгтгэл тайлангуудийн дүгнэлтуудийн биелэлтэд хийсэн мониторингийн дүнг энэ хурлын асуудлын 5 дугаарт хэлэлцэх байсан ч, ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэгдээгүй, сүүлийн 5 жилийн тайланг нэг л аудитын байгууллагын хандлагатай энэ жилийн аудитын байгууллагатай харьцуулах шаадлагатай гэж үзсэний дагуу дараагийн хуралд оруулахаар тогтсон. Харин энэ зөрүүний асуудлыг авилгатай тэмцэх газраар шалгуулах шаардлагатай эсэхийг АТГ-ын тайлбарыг сонсьё.

Л.Сүх-Очир: Хэрвээ ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл шалгуулж болно.

Б.Жигдэн: Тайлангийн зөрүү одоогоор авилгын хэмжээнд хүрээгүй, харин системээ сайжруулах хэрэгтэй байна.

Л.Гансүх: Хариуцлагыг хуулиар тодорхой болгох хэрэгтэй юм.

П.Эрдэнэжаргал: Үүнийг зүгээр орхиж болохгүй. Жигдэн гуай л авилга биш гэсэн хэдий ч, төрийн аудит шалгах ёстой байх..

Н.Баярсайхан: Хүний эрх хөгжил төв, Зориг сан хамтран энэ асуудал дээр мониторинг хийж байгаа. Энэ талаар бид ажлын хэсгийн хурлаар ярилцсан. Тэгээд гурван талаас тэнцүү тооны төлөөлөлтэй ажлын хэсэг гараад энэ зөвлөмжийн ул мөрөөр хаана ямар байгууллагад арга хэмжээ авах вэ гэдэг дээр ажлын төлөвлөгөө гаргаад ажиллаж гэж ярьсан. Түүнийгээ энэ шийдвэр дээрээ ажлын хэсэг байгуулж ажиллана тусгаж оруулвал яасан юм бэ.

Л.Гансүх: Ажлын хэсэг байгуулж ажиллана гэж оруулъя.

Н.Баярсайхан: Би нэг тодорхой жишээ хэлье. 2011 оны 5 дугаар сарын 11 нд Мэргэжлийн хяналтын газраас 57 дугаар тогтоолыг гаргаж байгаль орчны улсын байцаагч стратегийн ордыг шалгах, хариуцлага тооцох эрхгүй гэсний дараа Оюу толгой 11 сарын 5-нд УМХГазарт 200 сая төгрөгний “Toyota” машин 2 ширхэгийг бэлэглэсэн байдаг. Иймд төрөөс гарч байгаа тогтоол шийдвэр нь эргээд авилгын шинжтэй байна уу гэдгийг хянах байдлаар талуудын ажлын хэсэг гарч ажиллах шаардлага гарч байна. Θнгөрсөн жилийн хуралд оролцож байсан Авилгатай тэмцэх газрын даргаас асуухад “ямар нэгэн байгууллага бидэнд мэдэгдэж хүсэлт тавих хэрэгтэй, тэрний дагуу л бид шалгана” гэж хэлж байсан. Үүний дагуу байгаль орчны нэг байгууллага хүсэлт өгсөн ч ямар арга хэмжээ авсан нь одоог хүртэл тодорхойгүй л байгаа. Тэгэхээр гурван талын ажлын хэсэг гараад тайлангийн дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр, зөрүүний талаар ямар нэгэн арга хэмжээ авьяа.

Л.Гансүх: Таны хэлснээр ажлын хэсэг байгуулж ажиллана гэж шийдвэрлэсэн. Аажлын хэсэг нь шалгуулах зүйл гарвал, Авилгатай тэмцэх газарт өгч болно. Тайланг батлая гэсэн гишүүд гараа өргөнө үү.

Бүх гишүүд гараа өргөж дэмжив.

II. ХЭЛЭЛЦСЭН нь: Монголын ОУИТБС-ЫН 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн тухай

Л.Гансүх: 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг зохицуулагч Ш.Цолмон танилцуулна

Ш. Цолмон: Бид төлөвлөгөөний биелэлтийг урьдчилан тараасан ба ажлын хэсгийн хурлаар ярилцсан байгаа. /материалыг хавсаргав/

Л.Гансүх: 2013 онд манай ажлын хэсэг, алба сайн ажилласан. Гадаадад ч нэр хүндтэй болсон. Олон улсын хуралд Д.Ганхуяг сайд тэргүүтэй төлөвлөгчид оролцсон байна. Дотооддоо, бараг 1000 орчим хүний сургалт, семинар зохион байгуулсан гэдэг том амжилт юм. Мөн 25 сургагч багш, 28 хэвлэл мэдээллийн ажилтан бэлтгэсэн байна. Өөрөөр хэлбэл, бид хангалттай түвшинд ажилласан байна. Цаашид хийх гол асуудал бол цахим тайлагнал боловсруулах явдал. Хөрөнгө санхүүгийн асуудлаа шийдэх, гадаадын зөвлөх байгууллагын туслалцаатайгаар хэрэгжүүлнэ. Уул уурхайн яам хуулийн эхний танилцуулга яамдууд хүргүүлсэн, санал авч байгаа зэргээр ажил тодорхой түвшинд амжилттай байна. Биелээгүй гол ажил нь хуулиа хэлэлцүүлнэ гэж үзэж байсан учраас түүнийг дагасан гэрээ, хуулийн хэлэлцүүлэг зэрэг ажлууд хоцорсон. Европын сэргээн босголт банкины төсөл санхүүгийн тайлангаа өгөөгүй ч, хийх ёстойгоо хийнэ гэсэн байр суурьтай байгаа. Бид 2013 оны тайлангаа хангалттай болсон гэж үзэж байна. Ингээд тайлантай холбоотой шийдвэрийг танилцуулья. Зөвшөөрч байгаа гишүүд гараа өргөнө үү.

П.Эрдэнэжаргал: Бидэнд хийж чадахгүй байгаа нэг ажил бол олон нийтэд тайлангийн дүнг хүргэх асуудал юм. Өмнө бид хоцроод 2 жилийн өмнөх юм ярихад утгагүй байдаг байсан бол одоо тайлангаа дараа ондоо багтаагаад байгаа юм чинь энэ сайхан мэдээллээ олон нийтэд хүргэмээр байна.

Л.Гансүх: Тайлангийн үр дунг олон нийтэд түгээхийг ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонд даалгасугай гэсэн тавдугаар заалтыг нэмж оруулья.

Бүх гишүүд гараа өргөж, зөвшөөрөв.

III. ХЭЛЭЛЦСЭН нь: Монголын ОҮИТБС-ын 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийн тухай

Л.Гансүх: Дараагийн асуудал бол 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл хэлэлцэнэ. 2014 оны төлөвлөгөөний гол зорилго нь ОҮИТБС болон хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, эдгээрийн зарчмууд болон стандартыг нэвтрүүлэх чиглэлээр бид ажиллана. Шинэ стандартын 7 үндсэн шаардлагыг биелүүлнэ. Хүрэх үр дүн нь шинэ стандартын бүх шаардлагуудыг хэрэгжүүлсэн үр дүнг 2014 онд гаргахыг зорьж байна. Мөн ОҮИТБС-ын хуультай болохоор төлөвлөж байна. /танилцуулгыг хавсаргав/

Ж.Гомбожав: Төлөвлөгөө тарсан байгаа тул шууд саналаа хэлмээр байна.

Л.Гансүх: Санал хэлэх хүмүүс нэрээ өгнө үү.

Ж.Гомбожав: 2013 оны ажлын хэсгийн тайланг биш үйл ажиллагааны тайланг олон нийтэд мэдээлэх тухай яривал дээр байна.

Л.Гансүх: Тиймээ, түүнийг мэдээлэх тухай шийдсэн.

Ж.Гомбожав: Төлөвлөгөөний 15 дугаар заалтыг задалж оруулах хэрэгтэй байна. Тухайлбал, төлбөр тооцооны нэгдсэн төвлөрсөн системтэй болгох зөвлөмж байна. Их ач холбогдолтой арга хэмжээ тул үгээр нь төлөвлөгөөнд оруулья. Сангийн яам, уул уурхайн яам гээд салбар чиглэлээрээ тус тусдаа салангийн тоо байх тул нэгдсэн системд оруулмаар байна.

Л.Гансүх: Бид энэ ажлыг 2014 онд хэрэгжүүлэх чадавхигүй тул хурлын шийдвэрт асуудлыг судлая гэх саналтай байна.

П.Эрдэнэжаргал: Гэхдээ аудитын байгууллага татвар хураах үйл ажиллагааг төвлөрүүлэх талаар ярьсан.

Л.Гансүх: Энэ бол хэт нүсэр, үр дүн нь ашиглагдах боломжгүй ажил байж болзошгүй.

Ж.Гомбожав: Энэ тийм нүсэр биш. Бид дэд зөвлөлийн дурмийг хэлэлцэнэ. Түүний 7,8 дугаар зүйлийг эхний ээлжинд олон нийтэд мэдээлье гэсэн билээ. Жишээлбэл, Өмнөговь аймагт ямар компаниуд тусгай зөвшөөрөл эзэмшиж байна гэдгийг мэдээлнэ.

Л.Гансүх: Бид хуулинд заагаад, төлбөр тооцоогоо нягтлаад гаргаж өгснөөр тайландаа оруулна. Үүнийг гаргах ажиллагаа нь татварт төлдөг орлого, орон нутгийн төлбөр, Ашигт малтмалын газар, БОНХЯ-д төвлөрүүлдэг орлогыг төвлөрсөн тогтолцоонд оруулна гэж ойлгогдоод байгаа тул нүсэрдээд байна.

Ж.Гомбожав: Одоо бол зузаан тайлан гарч байна. Гэтэл иргэн цөөхөн тооны мэдээлэл сонирхож байгаа шүүдээ. Тиймээс төлбөр, хураамж, хандив, тусламж болон ямар лиценз эзэмшиж байгааг харж болохуйц сан хөмрөг байх хэрэгтэй байгаа юм. Ийм тоо Ажлын албан дээр байна уу? 1800 гаруй компанийг аймаг, сумаар нь харах сан хөмрөг бий юу?

Л.Гансүх: Харин тийм л учраас цахим болгох шаардлага гарч байгаа юм. Та бол төвлөрсөн төлбөр тооцооны гэсэн шүү дээ. Хэрэв бүртгэл гэвэл төвлөрсөн мэдээллийн сантай болох гэж төлөвлөгөөндөө нэмж оруулья.

Ж.Гомбожав: Тайлан гаргасан 1800 компаниуд яагаад аудит хийлгээгүй вэ? Ганцхан компани л аудит хийлгэсэн гэх юм.

Л.Гансүх: Бүх компаниудын санхүүгийн тайландаа аудит хийсэн гэдэгт итгэж байна. Харин аудитын нэгтгэгч нь тайлангийн 6 маягтаар гаргасан тоогоо дахин аудитаар баталгаажуулж тамга даруулах ёстой гэсэн шаардлагыг тавиад байна.

Ж. Гомбожав: Аудитынхан бол санхүүгийн аудитын хийлгэхээс гадна ажлын албанд 6 маягтын аudit хийлгэвэл болчихно гэсэн санал тавьж байна. Энэ чинь өөр шүү дээ.

Л.Гансүх: Аудитын байгууллага компаниудаар давхар ажил хийлгэж байна. Үүнийг бид хуулиндаа нягтлан бодогчид хариуцлага хүлээлгэхээр зааж өгөх хэрэгтэй.

Ж.Гомбожав: Тиймээ, бүх компаниуд санхүүгийн аudit хийлгэдэг байх ёстой. Тэр нь ажлын албан дээр хэн хийлгэж вэ гэдэг мэдээлэл сан хөмрөгт нь байх ёстой.

Л.Гансүх: Санхүүгийн аудитыг бүх компаниуд хийлгэж байгаа.

Ж. Гомбожав: Тэгвэл, яагаад ганцхан хийлгэдэг гэж хэлж байгаа юм бэ?

Л.Гансүх: ОУИТБС- ын тайлангийн 6 маягтаар гаргасан тайланг дахин санхүүгийн аudit хийлгэх зүйтэй гэж аудитын байгууллага санал болгоод байгаа.

П.Эрдэнэжаргал: Тиймээ, ил тод байдлын тайлан дээр аudit хийлгэх нь зүйтэй гэж хэлсэн. Уул уурхайн компани хуулийн дагуу санхүүгийн аудитыг хийлгэдэг гэж ойлгодог.

Л.Гансүх: Хуулинд нягтлан бодогч хариуцлага тооцно гээд хуулиндаа оруулах нь зүйтэй.

Ж.Гомбожав: Та өмнө нь наадам зэрэгт хандив өгснийг тайлагнах ямар шаардлагатай юм бэ гэсэн утгатай зүйл хэлсэн.

Л. Гансүх: Зөрүү хандив зэрэг дээр байна гэдэг утгаар хэлсэн.

Ж.Гомбожав: Би ажлын хэсгийн хурал дээр ч хэлж байсан. Хандив дээр авилгын асуудал байгаа юм биш үү.

Л.Гансүх: Харин зөрүү гараад байгаа нь өгсөн тал тайландаа бичээд, авсан тал нь актаар аваагүй болохоор тайландаа тусгахгүй, үүнээс болж зөрүү үүсч байгаа юм. Сумын захиргаа актаар хүлээж аваад, бүртгэхийг хуульчилах шаардлагатай байна.

Ж.Гомбожав: Амьдрал дээр актын дагуу хүлээн авахгүй байгаа тул ил тод болгох хэрэгтэй байна.

Л.Гансүх: Тийм, сайн боловсруулаад хуулинд зохих заалтыг оруулах хэрэгтэй байна.

Ж.Гомбожав: Миний гуравдахь санал бол ажлын албаны чадавхийг бэхжүүлэх гэдэг зөвлөмж бол хамгийн зүйтэй юм. Иймээс эхний ээлжинд бүртгэлийн болон хууль эрхзүйн 2 орон тоогоор нэмэх хэрэгтэй байна.

Л.Гансүх: Эхлээд дүн бүртгэл хариуцсан хүний орон тоог нэмье. Дараа нь хуулиндаа ажлын албаны зохион байгуулалтыг оруулж өгөх ёстой. Одоо бид улсын төсвөөс 266 сая төгрөг тусгаад 181 гаруй сая төгрөгийг аудитын төлбөрт төлж байгаа. Ажлын албаны зардлыг төслийн нэгж тул Дэлхийн банкины санхүүжүүлж байгаа юм.

Ж.Гомбожав: Би өмнө нь нэгтгэлд орсон 200 компанийн 149 нь гэрээ байгуулж, харин байгаль орчны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх тухай зөвхөн дөрөвхөн компани гэрээтэй байна гэсэн билээ. Ил тод байдлыг сум, аймаг огт мэдэхгүй байна.

Л.Гансүх: Тийм учраас бүх зохицуулалтыг хуулиараа л зохион байгуулж өгөх хэрэгтэй байна.

Ж.Гомбожав: Гарсан хуулиа мэдэхгүй байна..

Л.Гансүх: Бидэнд одоогоор хариуцлага тооцох хуулийн заалтгүй байна.

Ж.Гомбожав: Та, хуулиар бүх юмыг хаах гээд байна.

Л.Гансүх: Хуульгүй тул ямар үндэслэлээр торгох вэ?

Ж.Гомбожав: Хуулинд байгаа заалт хэрэгжихгүй байгаа тухай ярьж байна.

Л.Гансүх: Ашигт малтмалын газрын эрхлэх асуудлыг тухай яриад байна. Гэрээ байгуулаад мөнгөө тусгаагүй байна гэдгийг хэн хянах вэ? Зохицуулалтыг шинэ хуулиндаа оруулах нь зүйтэй байна.

П.Эрдэнэжаргал: Ашигт малтмалын хуулиар бүх компаниуд нэгдүгээр улиралд багтаагаад олон нийтэд бүх төлсөн татвараа мэдээлэх ёстой.

Л.Гансүх: Компаниуд хугацаандаа тайлан гаргасан эсхийг Ашигт малтмалын газар хяналт тавих үүрэгтэй. МХЕГ нь компаниуд тайлан гаргасан эсэхт давхар хяналт тавина. Харин авилгын хэрэг илэрвэл АТГ-т шалгуулах бичиг хэрэгтэй болохоор зохицуулах нь зүйтэй байна.

Ж.Гомбожав: Төрийн чиг үүрэг бүхий ажлыг хийх эрхийг төрийн өмнөөс үүрэг гүйцэтгэх төрийн бус байгууллагуудад өгөөч гэхээр өгдөггүй, мөнгийг нь төсөвлөдөггүй.

Л.Гансүх: Бид нар төрийн тэр чиг үүргийн байгууллага биш тул зөвлөмж гаргаад түүндээ уул уурхайн салбарын хяналт шалгалтын зарим чиг үүргийг ТББ-үүдад шилжүүлэх нь зүйтэй гэсний дагуу 2014 оны төлөвлөгөөндөө тусгаж, хэрэгжүүлэхэд дэмжих хүсэлтийг Уул уурхайн сайдад хүргүулье.

Ж.Гомбожав: 2014 оны төлөвлөгөөний хариуцах дээр нь яамдууд байгаа. Үндэсний зөвлөлийг Ерөнхий сайд ахладаг утгаар бололцоотой гэж ойлгож байна.

Л.Гансүх: Болно, Ерөнхий сайд үүрэг өгнө.

Б.Батболд: Төлөвлөгөөний 25 дээр байгаа хэвлэл мэдээллийн ажилтнуудын чадавхи сайжруулах сургалт зохион байгуулах гээд, гүйцэтгэх нь ТАН эвсэл гэсэн. Харин МБОИЗ нь оролцогч нэг талын хувьд тодорхой асуудал хариуцаж оролцох саналтай байна.

Л.Гансүх: ТАН эвсэл гэсэн бол та бүгд зөвлөлдөөд Төрийн бус байгууллагуудын эвсэл гэвэл нэрийг нь өөрчлөхөд бэлэн байна.

Б.Батболд: Иргэний нийгмийн байгууллага гэсэн дээр юм байна. Яагаад гэвэл МБОИЗ нь ТАН эвсэлд ордоггүй юм.

Л.Гансүх: Одоо таны хэлснээр ИНБ-үүд гэж оруулъя.

С.Энхтуяа:Худалдаа аж үйлдвэрийн танхимаас жил бүр ТОП-100 аж ахуйн нэгжүүдийг шалгаруулдаг. Энэ нь компаниудын хувьд нэр төрийн хэрэг болдог. Үүнтэй адил бидний хийж байгаа ОУИТБС-ыг хэрэгжүүлснээр шилдэг аж ахуйн нэгжийг шалгаруулах ажлыг 2014 оноос зохион байгуулах хэрэгтэй байна. Яагаад гэвэл ил тод байдал нь компаниудын хувьд нэр төрийн хэрэг болоод байна. Иймд том жижиг гэж ялгахгүй ямар нэгэн үнэлгээ гаргах хэрэгтэй байна.

Л.Гансүх: Үүнийг санал гэж хүлээн авлаа. Хэрэгжүүлэх тал дээр сайн зөвлөль.

С.Энхтуяа: Шилдэгт орно гэдэг нэр төрийн хэрэг юм.

Л.Гансүх: Сурталчилгааны нэг ажил болгож болох юм.

Энхтуяа: Хоёрдугаарт, компаниудаас авч байгаа мэдээллээ тайлбартай болгох хэрэгтэй байна. Тухайлбал, орон нутагт төлсөн төлбөр гээд байгаа нь нэг бол аймгаар, эсхүл яамаар жагсаагаад байна. Харин байгаль орчны барьцаа төлбөрийн талаар бол компаниуд БОНХЯ-аар төлөвлөгөөгөө батлуулахад энэ барьцаа 50 хувийг заавал төвлөрүүлсэн байх ёстой байдаг. Ер нь нөхөн сэргээлт дээр хэдхэн асуудал байдаг. Үүнд, нийт нөхөн сэргээлт, техникийн, биологийн нөхөн сэргээлт барьцаа, зардал гэсэн асуудлууд байдаг. Гуравдугаарт, сая бүртгэлийн хүн авахдаа геологи уул уурхайн мэргэжилтэй хүн байх нь зүйтэй.

Б.Баярмаа: 2014 оны төлөвлөгөөгөөр бид томоохон ажлуудыг хийнэ. Тухайлбал, шинэ стандарт, хууль батлуулах гэх зэрэг. Төлөвлөгөөг хараад маш амархан аргаар шинэ стандартыг хэрэгжүүлчихээр сэтгэгдэл төрөөд байна. Миний хариуцан хийж байгаа нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг ил тод болгоно гэжээ. Гэтэл энэ тухай мэдээллийг нэгтгэн авч хийхэд одоогийн хууль эрхзүйн орчин маш төвөтэй байна. Бид долоон газарт бичиг өгөхөд бие биерүүгээ шидээд аль ч газар хариу өгдөггүй. Харин мэдээлэл нь УБЕГазарт байдаг. Гэхдээ хуулиараа болохоор эзэн өөрөө албан бичгээр зөвшөөрсөн тохиолдолд гэсэн байдаг. Тэгээд ажлын албанаас энэ мэдээллийг хүсэхэд тэнд бас байхгүй гэж хэлсэн. Тэгсэн мөртлөө байхгүй мэдээллийг

нэгтгээд тавьчихна гээд ийм амархан шинэ стандартыг нэвтрүүлэх гэж байгаа нь энэ ажил чинь хий хоосон биелмээргүй харагдаад байна. Тэгэхээр энэ ажлыг яг ямар арга замаар хийх боломжтой вэ гэдэгт л асуудал байгаа юм. Үүн дээр ажлын хэсэг байгуулаад хийх арга зам, зөвлөмж боловсруулахгүй бол дараа жил биелэлт ярихад хууль батлагдсангүй, иймээс энэ хийгдэх боломжгүй байлаа гэсэн юм яриад сууж байх вий. Үүнийг сайн бodoх хэрэгтэй байна. Хэдийгээр үндсэн чиглэл дээрээ хууль батлуулахын төлөө ажиллана гэж байгаа ч төлөвлөгөөн дээрээ хууль батлуулахын төлөө юу ч хийхгүй байх юм шиг харагдаж байна. Зөвхөн Адам Смит байгууллага хуулийн төслийг олон нийтэд танилцуулна гэсэн л юм харагдаж байна. Гэтэл хуулийг чинь өргөн барих батлуулахад нилээн хэцүү л байдаг ш дээ. Энэ дээр юмнуудаа оруулмаар байна.

Л.Гансүх: Уул уурхайн яам хариуцаж байгаа..

Б.Баярмаа: Уул уурхайн яамны хийх ажил юм уу. Энэ төлөвлөгөөн дээр чинь байхгүй л байна ш дээ. Зөвхөн хуулийн төслийг олон нийтэд танилцуулна гэсэн юм байна. Тэгэхээр үүнийгээ төлөвлөгөөндөө оруулаад УУЯ-нд үүрэг болгоод өгдөг ч юм уу. Өргөн барих, батлуулахын тулд олон нийтэд хандсан нөлөөллийн ажил нилээд хийхгүй бол тийм ч амархан батлагдахгүй байх гэж бодож байна. Дараа нь мэдээлэл харилцааны шинэ стратегийг бид нилээн их мөнгө өгөөд, мэргэжлийн байгууллагаар хийлгээд танилцсан. Гэтэл 63,000 европийн ажил хийлгээд байгаа ч, энэ шинээр хийлгэсэн ажлын үр дүн стратегийг хэрэгжүүлэх талаар ирэх оны төлөвлөгөөн дээр туссан зүйл алга. Тэгэхээр олон нийтэд танилцуулахын тулд мэргэжлийн байгууллагын хийсэн стратегийг хэрэгжүүлэх талаар 2014 оны төлөвлөгөөн дээрээ тусгаж өгмөөр байна.

Л.Гансүх: Хэвлэл мэдээллийн ажлын хүрээнд гэдгийг та харсан уу.

Б.Баярмаа: Харсан, гэхдээ шинэ стратегийг хэрэгжүүлэх ажил гэж би ойлгохгүй байна.

Л.Гансүх: Холбоотой мэдээлэл сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол явуулах гэсэн байсан.

Б.Баярмаа: Тэр биш гэж ойлгож байгаа. 2 том судалгаа хийлгээд стратеги боловсруулж өгөх ёстой. Тэгэхээр үүнийг би тогтмол сурталчилгаанаас ялгаатай ойлголт гэж үзэж байна. Иймд стратегийн дагуу түүнийг хэрэгжүүлэх ажлыг оруулмаар байна. Тэгээд иргэний нийгмийнхэний хэлээд байгаа нь том тоог хүмүүс ойлгохгүйгээс, ач холбогдлыг ухаarahгүй байгаагаас ил тод байдлын тайланг хүмүүс мэдэхгүй байна гэж үзээд байна. Тийм учир тайланг ойлгомжтой, хүртээмжтэй, сонирхолтой болгох тал дээр юм сэдэж хийхгүй бол үр дүн гарахгүй байж болно. Уг нь шинэ стандартыг ханган

биелүүлэх гэдэг дээр их л гоё бичсэн байна. Тэгэхээр үүнийг хийхийн тулд юу хийх ёстой вэ гэдэгээ төлөвлөгөөн дээр тусгаж өгөх санал байна.

Дараагийн асуудал нь, энэ төлөвлөгөө нь ажлын албаных уу, ажлын хэсгийнх үү гэдэг нь ойлгомжгүй байна. Иргэний нийгэм хаана байх юм бэ? Үүнийг харахад хариуцах байгууллагууд нь төрийн том яамдууд л байна. Харин хамтрах байгууллагууд нь ажлын алба ч юмуу. Энд иргэний ниймгийн оролцоо хаана нь байх юм бэ? Эсвэл бид эд нар төлөвлөсөн ажлуудаа хугацаанд нь хийж чадаж байна уу гэдгийг хянаад байж байх юмуу? Мөн одоо бид Үндэсний зөвлөлийн хурлаар нилээд олон асуудлыг шийдвэрлэх байх. Энэ ажлын төлөвлөгөөн дээр суух уу.

Л. Гансүх: Ажлын алба гэдэг чинь иргэний нийгэм, төр, компани хамт шүү. Хурлаа ээлжилж даргална, бүх ажиллагаанд орно шүү дээ. Тиймээс иргэний нийгэм байна. Яам гэсэн чинь яамдууд гаргаж өгөх үүрэгтэй байхгүй юу.

Б.Баярмаа: Би нэг жилийн хугацаанд ажлын хэсэгт ажиллахад зүгээр хуралд сууж саналаа хэлж л суусан. Бодит оролцоо, бодит процесст оролцохгүй байна. Магадгүй, би өөрөө идэвхгүй байсан байж магадгүй. Энд одоо иргэний нийгмийн их үнэтэй цэнэтэй хүмүүс сууж байна. Энэ хүмүүсийн бодит оролцоог бий болгоход тодорхой нэг ажлыг баруулаад хийлгээч гэсэн саналыг хэлж байна. Эсвэл энэ ажлыг төрийнхөн хийгээд, иргэний нийгмийнхэн хянадаг байх юмуу. Энийг оролцоо болон гүйцэтгэх чиг үргийг нь тодорхой заагаад өгчихвэл, бид хамтарч ажиллах ёстой байх. Энэ бол төрийн байгууллагаас арай өөр бүтэц шүү дээ.

Л.Гансүх: Гэхдээ өөрөө процесст яагаад орохгүй байгаа юм. Баярсайхан, Алгаа гээд ажлын хэсгийн хурлыг ээлжилэн удирдаж байгаа. Ажлын хэсэг болгон дээр ярьж байгаа санал чинь процесст орж л байгаа ш дээ. Таныг хаагуур нь яагаад гаргачихаад байна?

Б.Баярмаа: Би санаачилгыг хурал гэж ойлгохгүй байна. би үүнийг илүү өргөн хүрээтэй үйл ажиллагаа гэж харж байна.

Л.Гансүх: Уранцоожийн хэлсэн хяналт тавих ажил дээр хэн ч оролцож болно.

Б.Баярмаа: Харин энэ ажлууд чинь төлөвлөгдөхгүй байна. Түүнд иргэний нийгмийг оролцуулах тухай гарч ирэхгүй байна.

Л.Гансүх: Баярмаагийн хэлсэн саналуудыг салгаж харуулья. Харин та процесст орохгүй байна гэдэг худлаа шүү. Хийх ажлуудаас үүнийг би хийе ээ гэвэл болно шүү. Харин алийг нь Баярмаа хийнэ гэж яаж оруулах юм бэ? Энэ чинь төвөгтэй ш дээ. Ажлын хэсэг гэсэн бол та бүгд орж л байгаа юм.

Б.Баярмаа: Энд чинь ажлын хэсэг биш ажлын алба гэсэн байна. Ажлын албандаа чинь иргэний нийгэм байхгүй ш дээ.

П.Эрдэнэжаргал: Тиймээ, одоо энэ маргааныг болье. Иргэний нийгэм гээд л орууляа.

Ж.Гомбожав: Би бол Баярмаагийн хэлж байгааг зөв гэж бодож байна.

П. Эрдэнэжаргал: Төлөвлөгөнд гүйцэтгэх байгууллагын тухай байхгүй байна. Зөвхөн хариуцах эзний тухай л байна. Би ч гэсэн ярих эрхтэй. Ганцхан та эрхтэй биш.

Ж.Гомбожав: Энэ төлөвлөгөөн дээр ТАН эвсэл гэдэг хоёрхон үг орсон байна. ТАН эвсэл гэдэг бол иргэний нийгмийн байгууллагын нэг л төлөөлөл юм. Баярмаагийн хэлснийг та нар бodoоч. Яг хийх хүн дээр нь ажлын алба гэсэн байна.

Л.Гансүх: Энэ төлөвлөгөөг та бүхний оруулсан саналын дагуу засна. Тэгэхээр та нар хийх эзэн дээр нь өөрийн нэрийг оруулна уу. Ажлын алба энийг чинь цааш нь задлана.

П.Эрдэнэжаргал: Энэ дээр чинь гүйцэтгэх байгууллага байхгүй байна ш дээ. Тиймээс энэ хүснэгтийнхээ толгойг сольчихвол бидний маргаан тасрах гээд байна.

Л.Гансүх: Хариуцах байгууллага гэсэнд ажлын алба гэдгээ ажлын хэсэг гэж бичье. Тэгээд та нар саналаа бичээд ажлын албандаа өгнө үү.

Н.Баярсайхан: Ирэх жилээс бид шинэ стандартын дагуу тайлангаа гаргах ёстой. Тэгэхээр ОУНБД нарын газраас нэг хүсэлт ирсэн байх ёстой. Энэ нь компаниудын жинхэнэ хувьцаа эзэмшигчдийг ил тод болгох асуудлаар туршилтын төслүүдийг тодорхой улсуудад хэрэгжүүлье, үүнд Монгол улс орох уу гэсэн санал ирсэн байх. Тэгэхээр энэ саналын хариуг явуулсан уу? Хэрвээ бид ярилцаад хариуг гаргачих бол нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийг ил тод болгох асуудлаар ийм ажиллана хийнэ гэж ажлын төлөвлөгөөндөө оруулах саналтай байна. Одоогоор явуулаагүй байгаа бол тэрний хариуг бүрдээрээ хэлэлцэж байгаад хариугаа ил тод гаргая.

Түрүүний ажлын хэсгийн хурал дээр энэ төлөвлөгөөний форматыг өөрчилье гэж Алгаа гуай хэлж байсан боловч хэвээрээ орж ирсэн болохоор маргаан үүсгээд байна. Төлөвлөгөөний 6 дээр санал байна.

Л.Гансүх: Бид өөрсдийн оруулах саналаа бичээд явуулъя гэж ярьсан шүү дээ. Тэгээд дараа нь ярилцаад оруулаад явчихвал болох уу?

Н.Баярсайхан: Гэхдээ зөвшилцлөөр санал хураахаар яах вэ?

Л.Гансүх: За тэгвэл саналаа хэл дээ. Ер нь хүний бичсэн саналыг ч гэсэн бичээд дараа нь солилцено ш дээ.

Н.Баярсайхан: Төлөвлөгөөний 6 дугаар ажил ойлгомжгүй байна. Энэ яг юу гэсэн уг вэ? Агуулга нь тодорхойгүй байгаад байна. Мөн 10,11 дүгээр ажил болон 25 дугаар ажлыг хараарай. Иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн ажилтнуудын чадавхи бэхжүүлэх сургалт гэж байна. Үндэсний түвшинд ажиллаж байгаа иргэний нийгмийн байгууллагыг хангалттай чадавхижуулсан. Одоо харин орон нутгийн түвшинд ажиллаж байгаа иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг чадавхижуулах сургалт хийх хэрэгтэй. Иймд орон нутгийн гэдэг үгийг эхэнд оруулъя. Дараагийн санал бол, 26,27 дугаар ажлыг яаж идэвхжүүлэх вэ гэдэг нь байхгүй байна. Мөн 29,30,31,32 дугаар ажил, орон нутгийн хурал семинарт идэвхтэй иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, жижиг компаниуд, тайланд хамрагддагүй компаниуд оролцож чаддаггүй гэдгийг бид орон нутгийн сургалтаас харсан. Энэ талаар би ажлын хэсгийн хурал дээр ч хэлсэн. Тухайлбал, хойд бүсийн хуралдаанд 60 гаруй хүний дотор зөвхөн 7-хон иргэн сууж байх жишээтэй. Тэгэхээр үүнийн аймаг бүрт нь хийе ээ. Тэгээд ажлын хэсгийн гишүүдэд хуваарилаад 25 сая төгрөгөө хувааж өгөөд явуулвал энд чинь нөгөө оролцоо чинь бий болох гээд байна.

Л.Гансүх: 25 сая төгрөг чинь 21 аймагт хүрэх үү. Арай л хүрэхгүй байх. Бидэнд хоёр л санхүүжилт байгаа. Улсын төсвөөс 270 сая төгрөг аудитын зөвлөхийн төлбөрт зориулж өгч байгаа, нөгөө нь Дэлхийн банкнаас 250 мянган доллар өгнө энэ нь ажлын албаны цалин бусад зардалд зарцуулж байгаа. гурав дахь нь Европын сэргээн босголт банкны санхүүжилт бий. Түүнд бид нар орох эрхгүй мөнгө юм. Тэгэхээр хэдүүлээ сайн ярилцая. Харин оролцогчдоо давхардуулахгүй ч юм уу замаар шийдэх хэрэгтэй байх. Иймд бүгдээрээ төлөвлөгөөний төсөлд саналаа өгчих. Тэгээд таных шиг санал гарч ирвэл мөнгө төгрөгөө яах вэ гэдэг дээр дахиад ярилцая.

Н.Баярсайхан: Тэгвэл уул уурхай идэвхтэй явж байгаа аймгуудад гэдэг ч юмуу тодорхой байдлаар тусгаж өгмөөр байна. Аймаг бүрт нь хийснээр, тэнд жижиг компаниуд иргэний нийгмийнхэн, иргэд оролцох илүү боломжтой болох юм. 33 дугаар ажил дээр Үндэсний зөвлөлийн хурлыг жилд нэгээс доошгүй гэдгийг хоёр болгож оруулмаар байна. Мөн 34,37 дугаар ажлуудыг нэг болгож оруулмаар байна.

Уранцоож: Би 10,11 дүгээр ажлыг тодруулмаар байна. Энэ ер нь хэрэггүй л юм шиг санагдаад байна. Угаасаа л маягтаараа гаргачиж байгаа ш дээ.

Ш.Цолмон: Энэ бол Жигдэн гуайн яриад байгаа асуудал л даа. Олон улсын хуучин дүрмийн 15,16 дугаар шаардлага гэж явдаг байсан. Энэ нь ОУИТБС-ын тайлангуудын үнэн зөв байдлыг баталгаажуул гэсэн уг юм. Хэдийгээр захирал, нягтлан нь гарын үсэг зурсан ч гэсэн энэ нь ОУ-ын түвшинд хэр найдвартай вэ гэдгийг л баталгаажуулах асуудал юм. Үүнээс гадна Засгийн газрын тайланг бас шатанд нь

баталгаажуулах шаардлагатай юм. ОҮИТБС-ын орон нутгийн тайланг тухайн орон нутгийн аудитын байгууллагаар баталгаажуулах ёстай л гэсэн шаардлага юм. Гэвч амьдрал дээр ерөөсөө хэрэгждэггүй юм. Сангийн яамтай олон удаа хэлэлцэж байсан юм. Тэгээд үүнийг хэрэгжүүлэх талаар ядаж нэг журам гаргаж ажиллах зорилгоор төлөвлөгөөнд оруулсан. Хуулиар бол 50 саяас дээш үл хөдлөх хөрөнгөтэй компаниуд жил бүр аудитад орж байна. Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланд сууриссан ил тод байдлын тайланг гаргана. Тэгэхээр тайлангаудитаар баталгаажуулахаар заавал мөнгө гарах болоод байгаа.

Л.Гансүх: Журам гаргах гэдгээ судлах болгоод оруулъя..

П.Эрдэнэжаргал: Аудитын гэдэг үгийг авах хэрэгтэй байна. Угаас аудитаар орсон тайлан шүү.

Л.Гансүх: Одоогоор аudit гэж үлдээе. Судалж л байгаа шүүдээ.

Г.Уранцоож: Төлөвлөгөөний 15 дээр Үндэсний тайланд өгсөн зөвлөмжийн давхардлыг судлах гэдэг нь энд орох шаардлагагүй байна. Харин мониторингийн дүн гарахаар түүнд үндэслээд зөвлөмжийн биелүүлэх төлөвлөгөө боловсруулах, зарим нэгэн биелэх боломжтой юмыг нь 2014 ондоо оруулмаар байна. Судалгаа нь бол одоо явагдаж байгаа. .

Л.Гансүх: За тэгвэл наад санал оруулахаар өөрөө үг үсгээ хянаарай.

П.Эрдэнэжаргал: Тухайлбал өнөөдрийн гаргаж байгаа зөвлөмж дээр санал зөрөөтэй юм байгаа. Тэгэхээр энэ зөвлөмжийг автоматаар аваад байх юм уу.

Л.Гансүх: Аудторууд юу зөвлөхөө өөрсдөө мэднэ. Харин бид авахаа авна Харьцуулсан судалгаа хийхээр маш сонирхолтой юм харагдана. Үүний дагуу юу нь хэрэгтэй, ямар ч байсан төлөвлөгөө гаргах нь ойлгомжтой болно.

П.Эрдэнэжаргал: Гэхдээ, нягталж судалж гэж оруулэх хэрэгтэй.

Л.Гансүх: Тэдгээрийг тухайн үед нь ярилцья.

П.Эрдэнэжаргал: Олборлох үйлдвэрлэлийн төрийн өмчит компаниудаас гаргасан хувь эзэмшил гэж юуг хэлээд байгаа юм бэ?

Ш.Цолмон: Охин компани, салбар компани зэргийг хэлж байна.

П.Эрдэнэжаргал: Тэрийг тодруулахгүй бол энэ чинь ойлгогдохгүй байна.

Л.Гансүх: Тэгвэл хувь эзэмшил гэдгийн ард хаалтанд “охин компани” гээд бичье.

Б.Отгонсайхан: 6 дугаар ажил дээр томъёололыг нь жаахан өөрчилвэл хэрэгтэй байна. Шаардлагын дагуу төрийн өмчит компаниуд ил тод байдлын тайлан гаргах

ёстай. Тэгэхээр ТӨХ болон Эрдэнэс Монгол компанид ил тод байдлын тайланд ТӨК-үүд үлгэрлэж эсвэл манлайлан оролцоно гэсэн утгаар оруулж Үндэсний зөвлөлөөс зөвлөмж хүргүүлмээр байна.

Л.Гансүх: Энэ чинь шинэ заалт болж орж ирэх байх. Нэмэлт өөрчлөлт гэсэн хэсгийг нэмж оруулаад гишүүд рүүгээ мэйлээр явуулчих. Өөрсдөө хянаад явуулсны дараа би өөрөө хянаж үзье. 2014 оны төлөвлөгөөг нарийвчилан задлана. За ингээд энэ асуудлаа батлая.

IV. ХЭЛЭЛЦСЭН нь: ОУИТБС-ыг орон нутагт хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, дэд зөвлөлийн ажиллах журмын төсөл

Н.Баярсайхан: Дүрмийн төслийг та бүхэн хүргүүлсэн байгаа. Төлсөн авснаа нийтэл эвсэл бол 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө дөрвөн нөлөөллийн ажил, гурван мониторингийн ажлыг нээлттэй нийгэм форумын санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа. Эдгээрийн нэг нь Засгийн газрын 222 дугаар тогтоолд "...орон нутгийн засаг захиргааны нэгжид дэд зөвлөл байгуулагдан ажиллана" гэж заасан байсан. Үүний хэрэгжилтийг шалгах улмаар дүгнэлт гарган зөвлөмж гаргах зорилготой мониторинг хийсэн. Энэ ажлыг хийхэд ажлын албанаас дөрвөн бусийн семинарыг зохион байгуулсан нь мэдээлэл цуглуулах, судалгаа авах боломжийг хангаж өгсөн. Энэ мониторингийн дүгнэлтийг ажлын хэсгийн хурал дээр дэлгэрэнгүй танилцуулсан байгаа. Засгийн газрын 222 дугаар тогтоолд орон нутагт дэд зөвлөл байгуулагдахыг зааж өгсөн, бусад яам, төр захиргааны байгууллагуудын ажлын чиг үүргийг тодорхойлж өгсөнөөрөө нилээд давуу талтай, мөн санаачилгын маягтад ороогүй зарим мэдээллийг ил тод болгохыг журмаар зохицуулж өгсөн нь сайн тогтоол болжээ гэж дүгнэж байгаа. Мөн нөхөн сэргээлтийн барьцаа, зарцуулалт зэргийг оруулж өгөх болсон нь сайшаалтай юм. Гэхдээ бас сайны хажуугаар саар зүйл байна. Тухайлбал, ОУИТБС Монгол улсад хэрэгжээд 7 жил болсон хэдий ч хүмүүс сайн мэдэхгүй байна гэсэн байгаа. Иймд ил тод байдлын санаачилга өөрөө хаалттай байна гэсэн дүгнэлтийг өгч байсан. Тэгэхээр энэ тогтоолоор дэд зөвлөлийн зорилго, чиг үүргийг тодорхой зааж өгөөгүй байна. Жишээлбэл, Үндэсний зөвлөл болон ажлын хэсгийн чиг үүргээс юугаараа ялгаатай юм бэ гэдгийг зааж өгөөгүй. Дэд зөвлөлийн бүтэц зохион байгуулалтын хувьд аль ч түвшиндээ нэг зарчимтай байгуулагдах хэдий ч талуудын төлөөллийг хэрхэн хангаж оруулцах талаар зааж өгөөгүй байна. Орон нутгийн зөвлөлийн дотоод засаглалын асуудлыг заагаагүй юм байна гэж дүгнэсэн. Дэд зөвлөлийн үндсэн чиг үүрэг нь санаачилгыг хэрэгжүүлэх үндсэн төлөвлөгөөтэй байх. Тэр төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр, хариуцах эзэн нь тодорхой байхаар заах шаардлагатай. Орон нутгийн түвшинд Засаг дарга ахлахаар заасан боловч нарийн бичгийн дарга нь ажлын дайвар маягаар ажиллаж байгаа нь санаачилгыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхэд сөрөг нөлөөтэй байна гэж дүгнэсэн гэх зэргээр бид дүгнэлт гаргаад зөвлөмж гаргах ёстай байсан. Гэхдээ зөвлөмжийг ажлын хэсгийнхэнд гаргах

учраас бид дүрэм боловсруулах нь зүйтэй юм байна гэдэг шийдэлд хүрсэн.
/танилцуулгыг хавсаргав/

Энэ дүрэм нь 7 бүлэг, 44 зүйлтэй байгаа. урьдчилан тараасан учраас та бүхэн саналаа өгнө биз.

Л.Гансүх: Энэ бол дүрэм байх нь зайлшгүй юм байна лээ. Одоо дүрмээ баталлаа гэхэд нарийн бичгийн дарга нарын санхүүжилт чинь шийдэх боломжгүй байна. Дэлхийн банктай ярьж зөвшилцөөгүй байна гэх мэт асуудлууд байна.

Н.Баярсайхан: Бид үүнийг судалсан. Эхний ээлжинд дэд зөвлөл байгуулагдах 21 аймгийн 103 сум байна. Дэд зөвлөлийн хурлаар төлөвлөгөөгөө батлаад орон нутгийн ИТХ-д оруулаад батлуулах юм бол уул уурхайн үйлдвэрлэл явагдаж байгаа суманд орон нутгийн хөгжлийн сан, засаг даргын нөөц сан гэх мэт сангуудаас санхүүжих боломжтой юм. Энэ нь өдөр бүхэн ажиллаад байхгүй учраас аймаг дээр хөгжлийн бодлогын хэлтсий мэргэжилтэн, суманд бол байгаль орчны улсын байцаагч эхний 2 жилийн хугацаанд хариуцаад явах цаашдаа иргэний нийгэм, компаниуд эзэлжлээд удирдаад явах боломжтой юм. Тэгээд өдөр бүхэн ажиллахгүй учраас ажлын цагийг хагас цагаар тооцоод, улиралд нэг удаа урамшуулал өгөөд яваад байх бололцоотой юм гэсэн саналыг гаргаж байсан.

Д.Дамба: Дүрмийн 13,1-13,2 дээр зааснаар дэд зөвлөлд орж ажиллах ИНБ, компанийн төлөөлөлүүд нь тэнцүү тоотой байх уу?

Н.Баярсайхан: Тиймээ, тэнцүү тоотой байна. Тоог нь ИТХ-аас тоог тогтоогоод өгчихнэ. Засаг дарга төрөөс оруулах хүнээ томилоод чөлөөлөөд өгчихнэ, иргэний нийгмийн төлөөллийг иргэний нийгмийн хурал эсвэл багийн иргэдийн хурлаас томилж, чөлөөлнө харин компанийн төлөөллийг компаниудын хурлаас томилж, чөлөөлнө.

Д.Дамба: Компаниудын хурлыг хэн зохион байгуулах юм бэ?

Н.Баярсайхан: Дүрэм дээр энэ талаарх заалт байгаа. Аймаг сумын ЗДТГ зохион байгуулна гэж заасан байна.

Л.Гансүх: Би зохион байгуулалтын талаар сайн бодсон байх гэж найдаж байна. Харин санхүүжилтийн асуудал дээр хэдэн юм асуумаар байна. Нэгдүгээрт, 41 дээр "...санхүүгийн эх үүсвэр нь дотоод гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өгсөн хандив тусламж, төрийн байгууллагын тусгай сангуд, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөс бүрдсэн байж болно" гэж байна. Би нар чинь хандивыг эсэргүүцээд байгаа мөртлөө хандив тусламжаар санхүүжиж болох уу? Энэ бол зөрчилтэй л юм болж байна.

Н.Баярсайхан: Олон улсын байгууллагуудын хандив байж болно.

Л.Гансүх: Энэ дээр олон улсын байгууллагын гэж оруулаагүй байна.

Н.Баярсайхан: Гадаадын төрийн бус байгууллага орно л доо.

Л.Гансух: Ер нь бол төсөл, хөтөлбөр гэдгээр байвал болно. Дараагийн асуулт бол, "...аймаг, сум, дүүргийн ЗДТГ-ын ИТХ-аар батлуулан санхүүжинэ" гэсэн байна. Хэрвээ ингэж оруулвал хууль гарч байж л иргэдийн хурлаар төсөв батлагдах ёстой. Санхүүжилт нь байхгүй ажлыг ИТХ батлахгүй ш дээ. Тэгэхээр бид хууль гарахаас наана энэ журмыг хэрэгжүүлж чадахгүй гэсэн үг. Гуравдугаарт, дэд зөвлөлийн нарийн бичгийн даргыг чадавхижуулах, сурчилгааны тараах материалыг хэвлүүлэх, сургалтад оролцох арга хэмжээ авах зардлыг ажлын алба санхүүжүүлнэ" гэж оруулжээ. Ажлын алба үүнийг санхүүжүүлэхгүй л дээ. Харин ажлын албаны зардалд ийм, ийм зардлыг оруулж тооцно гэвэл иргэдийн хуралд тэр зардлаа батлуулахад хэрэг болно байх. Энэ дүрмийг манай иргэний нийгмийнхэн боловсруулсан юм чинь гайгүй байх гэж бодсон чинь зөвхөн санхүүжилтийн хэсгийг гэхэд болоогүй зүйл их байна. Тэгэхээр зарчмын хувьд зөвшөөрвөл журмаа батлая гэсэн шийдвэр гаргая.

П.Эрдэнэжаргал: Чиг үүргийг тусад нь гаргах хэрэгтэй байна. Ерөнхий зүйл гээд тэр дотроо орчихсон байна. Тэгээд бүтэц зохион байгуулалт гээд явчихсан байна.

Л.Гансух: Ажлын хэсгийн хурлаар орсон хэдий ч зөвхөн санхүүжилт гэхэд л өөрчлөлт орохоор харагдаж байна. 2014 оны төсвийг бүх иргэдийн хурал батласан тул тодотгол оруулж батлуулахаас нааш төсөвгүй гэсэн үг. Тиймээс үүнийг дараагийн хурлаар оруулахаар тохирох саналтай байна.

Н.Баярсайхан: Үйл ажиллагааны чиглэл гэж жагсаалт байсан. Гэхдээ энэ бол дүрэмд байх ёсгүй гээд хассан юм.

Л.Гансух: Тайлангуудын зөвлөмжийг биелүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж хэлэлцэх гээд он гараад 2 дугаар сард дахин хуралдахаар болж байна. Тэр хурлаар дахин хэлэлцэе.

Н.Баярсайхан: Тэгвэл зөвхөн санхүүжилтийн асуудлаас болоод хойшлууллаа гэж ойлгож болох уу.

Л.Гансух: Угаасаас санхүүжилт байхгүй юм чинь хэрэгжих боломжгүй ш дээ

Н.Баярсайхан: Бид дахин хэлэлцэх гэсээр байтал 4-5 сар болно.

Л.Гансух: Хэлэлцлээ, гээд орон нутагт яаж хэрэгжих юм бэ?

Н.Баярсайхан: Орон нутгийн түвшинд санаачилгыг яаж хэрэгжүүлэх вэ?

Л.Гансух: Санхүүжилт байхгүй байхад орон нутагт хэрэгжих боломжгүй ш дээ.

Ж.Гомбожав: Одоо хэдэн аймагт дэд зөвлөл байгаа билээ?

Н.Баярсайхан: 16 аймагт дэд зөвлөл байгаа.

Ж.Гомбожав: Тэд яж ажиллаж байгаа юм.

Л.Гансүх: Байгуулагдаад л явж байгаа.

Ж.Гомбожав: Тэгвэл тэгээд байгуулагдаад л явж байг л дээ. Санхүүгийн ажил бол тусдаа шүүдээ. Харин мөнгөтэй болвол илүү сайн ажиллана. Хойш тавьсанаар бидэнд ашиг байхгүй. Ажиллаж байвал 16 аймагт ажиллаад болоод байгаа юм чинь байгуулагдаад ажиллаж л байг л дээ. Уул уурхайн явуулдаг 103 сүм байна гэж байна. Бид бүсийн сургалт семинар хийсэн. Тэнд ажиллаж байгаа хүмүүс мөнгө өгөөч гэж хэлээгүй, гэхдээ мөнгөтэй болгочихвол улам сайжрах юм байна гэж бид ойлгосон юм. Тэгэхээр хойшлуулах шаардлагагүй. Дүрэмтэй болоод явах нь зөв. Санхүүгийн асуудлыг нь 2014 оны 7 дугаар сарын 1-нээс шийднэ гэж болно шүүдээ.

П.Эрдэнэжаргал: Үүнийг зөвлөмж болгох нь зүйтэй байна.

Л.Гансүх: Нэгэнт байгаа салбар зөвлөлүүд чинь ямар ч журамгүй, ямар ч эрхзүйн орчин байхгүй байна. Бид хэрвээ хуультай бол эрхзүйн орчиноо ойлгомжтой болгоно шүүдээ. Одоо бол цэвэр сайн дурын үндсэн дээр иргэний нийгмийн байгууллага гэдэг шиг бүтэц явж байна. Үүнийг бид ИТХ-д албажуулах гээд байгаа юм. Жишээлбэл, дэд зөвлөл хэдэн хүнтэй, хаанаас, хэн хэн сонгогдсон байна?

Ж.Гомбожав: Энэ дэд зөвлөлүүд чинь Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан, албажчихаад байгаа юм.

Л.Гансүх: Бид бүх юмыг иргэдийн хуралд албажуулах ёстой юм. Тэгэхээр бичиг цаас, албан бичгийн толгой гээд албаны болгох ёстой. Тийм учирг албан ёсны санхүүжилттэй бүтэц явах ёстой. Тамга тэмдэг хийж өгнө.

Н.Баярсайхан: Таны хэлж байгаа түвшинд хүрвэл маш сайн байна. Бид орон нутгийн хэмжээнд санаачилгыг сурталчилхаар ажиллаж байна. Дэд зөвлөлийг яж байгуулах юм, төрийнхөн яж ажиллах вэ гэдгээ мэдэхгүй байгаа учраас эхний ээлжинд зөвлөмж гаргачихъя.

Л.Гансүх: Одоохондоо дэд зөвлөлийн дүрмээ зөвлөмж болгоё. Шинэ хуулиндаа салбараа дүрмээр нь оруулья. Тэгээд төсөв энэ тэр бүх юмаа тусгаж өгье.

Н.Баярсайхан: За тэгье.

Л.Гансүх: Хурлын шийдвэрээ зөвлөмж гэдгээрээ батлава.

Б.Батболд: Хариуцах хүн нь хэн байх вэ. Аймаг орон нутагт Засаг даргын орлогч гэдэг ч юмуу.

Л.Гансүх: Тэрнийгээ зөвлөмж дээрээ сайн оруулаарай.

Н.Баярсайхан: Тэр талаар оруулсан байгаа.

Л.Гансүх: Дүрмийг зөвлөмж болгоод батлав. Нэмж, хасах саналаа өгөөд, зөвлөмж хэлбэрээр тараая.

Д.Дамба: Дүрмийн 32,2 дугаарт бүхий л гэрээ түүний хэрэгжилтийг шалгана гэсэн байна. Минийхээр бол бүхий л гэдэг үгийг хасаад төрийн байгууллагатай байгуулсан гэрээ гэж оруулмаар байна.

Л.Гансүх: 2013 онд сайн ажилласан гэдгийг би хариуцлагатайгаар хэлье. Ирэх долоо хоногоос энэ юмнуудаа янзалж нэгтгээд материалыа сайн бэлтгээд 1 сарын эхний долоо хоногт хэвлэлийн бага хурлаа хийе гэж бодож байна.

Бид ил тод байдлын хуультай, цахим мэдээллийн сантай нилээд өөр тувшинд ирэх 2014 оныхоо хурлыг хийхийн төлөө ажиллана гэж бодож байна. Та бүхэн улам идэвхтэй оролцоорой.

Хуралдаан 20 цаг 20 минутад дуусав.

Хуралдааны тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,
Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга



Л.Гансүх

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн ажилтан



А.Оtgontungalag